



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Хот нийтийн аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "л", Нийслэлийн Эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.10, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.3-ыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 07 дугаар, 2017 оны 9/10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд 2019 онд хийгдэх тохижилт, ногоон байгууламж, бүтээн байгуулалтын ажлуудын хүрээнд орчны эрүүл аюулгүй, тав тухтай байдлыг хангуулах, өнгө үзэмжтэй байлгах, ажил үүргийн уялдаа холбоог хангах зорилгоор ДААЛГАХ нь:

1. Дүүргийн Засаг дарга нарт:

1.1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ногоон байгууламжид худалдаа үйлчилгээ явуулах зорилгоор тавигдсан ч ашиглагдахгүй байгаа сүүдрэвч, саравчнуудыг буулгах, суурийг бүрэн авах, орчныг цэвэрлэх;

1.2. Автобусны эцсийн болон дундын зогсоолууд дахь хуучин сүүдрэвчүүдийн өнгө үзэмжийг сайжруулж, будаж засварлах, сандал, хогийн сав байршуулах ажлыг зохион байгуулах;

1.3. Орон сууцны болон гэр хорооллын гудамж зам талбайн гэрэлтүүлгийн шонгуудын унжсан цахилгааны болон шилэн кабелиудыг стандартын дагуу цэгцлэх, гэрлийн шонг тагжуулах ажлыг зохион байгуулж аюулгүй байдлыг хангах;

1.4. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний байгууллагуудын хариуцах орчны 50 метр талбайн зураглалыг хийлгэн, мэдээллийн сан үүсгэж, "Худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээ"-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулж, тохижилт, ногоон байгууламжийг арчлах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авах, хэрэгжилт, үр дүнг тооцох;

1.5. Явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж буй шон, гадас, хаалт, хашлага зэргийг буулгаж аюулгүй байдлыг хангуулах, эвдрэл бүхий явган замыг засварлах, сул шороон хөрс бүхий газрыг зүлэгжүүлэх, хатуу хучилттай болгон тохижуулах зэрэг ажлуудыг 2019 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах.

2. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрмийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд авто замын тэмдэг, тэмдэглэл, хайс, хашлаганы бүрэн бүтэн, өнгө үзэмжтэй байдлыг хангах, ажил үүргийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Ж.Тогтохбаяр/, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /Ч.Однасан/, Тээврийн цагдаагийн алба /Д.Амарсайхан/, "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ /Б.Баянмөнх/-т.

2.1. Энхтайваны өргөн чөлөө болон бусад төв замуудын зорчих хэсгийн замын эвдрэлийг засварлах, шаардлагатай тэмдэг, тэмдэглэлийг холбогдох стандартын дагуу шинээр хийх, нөхөн тавих;

2.2. "Нийслэлийн гудамж замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалтайгаар оролцуулах түр зөвшөөрөл олгох журам"-д заагдсан гудамж замуудад шаардлагатай тэмдгийг нөхөн байршуулах;

2.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хайс хашлагыг засаж хэвийн болгох, дутууг нөхөх, шаардлага хангахгүй болсон хайсыг зөөж шилжүүлэх, нийслэлийн өмчид бүртгэлжүүлэх.

3. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр автомашины хөдөлгөөнийг хязгаарлаж шон, хашаа, хаалт, гинж, тросс, түгжих хэрэгсэл байрлуулсан үйлдлүүдийг таслан зогсоож, гэм буруутай этгээдээр авто зам, явган зам, ногоон байгууламжийг эргүүлэн хэвийн байдалд оруулах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Ж.Тогтохбаяр/-т.

4. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн хашаалсан, нийтийн эзэмшлийн газрыг чөлөөлж тохижуулах, эзэмшиж буй газраа тохижуулаагүй, зориулалтын дагуу ашиглаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /Э.Болорчулуун/-нд.

5. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай болон орон сууцны хороолол доторх орчныг тохижуулах, арчлах, цэвэрлэх, сандал, хогийн сав, хогийн бункер, цинкэн савнуудыг засварлах, өнгө үзэмжийг сайжруулах, ариутгаж халдваргүйжүүлэх, гэрэлтүүлгийн болон гэрлэн дохионы шон дээр нааж буй зарыг тухай бүр хуулж, цэвэрлэх, арга хэмжээ авахыг "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ /Б.Бямбадорж/, "Монголын Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл" ТББ /М.Галбаатар/, дүүргүүдийн Хог хаягдлын үйлчилгээ, тээвэрлэлтийн байгууллагуудын удирдлагуудад.

6. Гэрэлтүүлгийн болон гэрлэн дохионы шон дээр зар нааж зөрчил гаргаж байгаа иргэн, хуулийн этгээдийг олж тогтоох, хяналт шалгалт явуулах, зөрчил, дутагдлыг давтан гаргахгүй байх, холбогдох хуулийн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авч, тайлагнаж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/-т.

7. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа төв зам дагуух эрүүл мэнд, боловсрол, худалдаа үйлчилгээний байгууллагуудын орчны тохижилтыг сайжруулж, аюулгүй байдлыг хангуулах, хаяг, мэдээллийн байгууламжийг холбогдох журамд тавигдсан шаардлагын дагуу шинэчлэн хийлгэх, байршуулах, орчны 50 метрт бий болгосон ногоон байгууламжуудыг арчлах, тэдгээрийн хайс хашлагуудыг засварлах өнгө үзэмжийг сэргээж будуулах арга хэмжээ авахыг дүүргүүдийн Засаг дарга нар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Нийслэлийн Боловсролын газар /Ж.Гантулга/-т.

8. Инженерийн шугам сүлжээний худгийн тагуудын бүрэн бүтэн байдалд 2019 оны 04 дүгээр сард багтаан үзлэг шалгалт явуулж, шинэчилж солих, өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангуулах, автозам, явган замын байгууламжид хийгдсэн худгийн тагуудын түвшинг тааруулах ажлыг 2019 оны 2 дугаар улиралд багтаан засварлаж, шинэчилж дуусгах, тэдгээрт шаардагдах зардлыг байгууллагын төсвөөс шийдвэрлэхийг ашиглалт хариуцсан инженерийн хангамжийн байгууллагууд /"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК, "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨК, "Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ, "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ, "Геодези, усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ, "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ, "Замын хөдөлгөөний удирдлагын төв" НӨҮГ, "Хувийн орон сууц, нийтийн аж ахуйн хөгжлийн төв" ТББ, "Орон сууц нийтийн аж ахуйн мэргэжлийн холбоо" ТББ/-ын удирдлагуудад.

9. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн шон, замын хөдөлгөөний гэрлэн дохионы шонгуудын унжсан болон ил байгаа утас, цахилгааны болон шилэн кабелуудыг цэгцлэх, тагжуулах зэргээр иргэдийн аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/, "Замын хөдөлгөөний удирдлагын төв" НӨҮГ /Д.Одбаяр/-т.

10. Үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээний ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэж, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, их хэмжээний ус тогтдог авто зам, замын байгууламжийн засвар үйлчилгээг графикийн дагуу зохион байгуулж ажиллахыг "Геодези, усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ /Т.Цэрэнноров/-т.

11. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн арчлалт хамгаалалтыг сайжруулах; бүртгэлжүүлж эзэнжүүлэх, засвар үйлчилгээг хийлгэх, хариуцлагыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг бий болгох асуудлыг судалж хэрэгжүүлэхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд.

12. Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж, хэрэгжилт үр дүн тайлагнаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд, хэрэгжилтийн явцад хяналт шалгалт явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ


С.АМАРСАЙХАН